



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 1118

Алтай хот

**Төлөвлөгөө батлах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, Хууль тогтоомжийг сурталчлах 2023 оны төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж улирал бүрийн дараа сарын 05-ны өдрийн дотор Хууль, эрх зүйн хэлтэст тайлагнаж ажиллахыг сум, агентлаг, албан байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3.Тайланг нэгтгэж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Золжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР